

**Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын
Ажлын хэсгийн хурлын протокол**

№3

Ажлын хэсгийн хурал 2008 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн 15.00 цагт Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн хурлын танхимд болов.

Ажлын хэсгийн хуралдаанд Ерөнхий сайдын ахлах зөвлөх, Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга, Ажлын хэсгийн ахлагч Д.Батбаяр, Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрын дарга, ажлын хэсгийн гишүүн н.Билэгсайхан /орлож мэргэжилтэн Цэгц/, Нээлттэй нийгэм форумын менежер, ажлын хэсгийн гишүүн Н. Дорждарь, Ил тод сангийн тэргүүн, ажлын хэсгийн гишүүн Ц. Ганболд, Уул уурхайн ассоциацийн гүйцэтгэх захирал, ажлын хэсгийн гишүүн Н. Алгаа, Инфорум төвийн гүйцэтгэх захирал, ажлын хэсгийн гишүүн Р.Батпүрэв, Онги голынхон хөдөлгөөний тэргүүн, ажлын хэсгийн гишүүн Ц.Мөнхбаяр, Засгийн газрын ахлах референт, ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Э.Сумъяа нар оролцов. Хуралдаанд урилгаар ОУИТБС-ын Ажлын албаны зохицуулагч Ш. Цолмон, ОУИТБС-ын Ажлын албаны санхүүгийн ажилтан Т. Хүрэлчимэг нар оролцов. Хуралд ажлын хэсгийн 23 гишүүн оролцох ёстой байсан боловч 8 гишүүн оролцож ирц 34,7 %-тай байлаа.

Ажлын хэсгийн хуралдааныг Ажлын хэсгийн ахлагч Д. Батбаяр нээв. Тэрээр та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. Зайлшгүй яаралтай учир шалтгааны улмаас Ажлын хэсгийн өнөөдрийн хурал болж байна. ОУИТБС-ыг Дэлхийн банкны санхүүгийн тусламж дэмжлэгтэйгээр 2007-2008 онд хэрэгжүүлж байгаа билээ. Цаашид энэ санаачилгыг хэрэгжүүлэхэд Дэлхийн банкнаас тусламжийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэн сонирхол аль аль талд маань байгаа учир энэ дэмжлэгээ үргэлжлүүлэн авах хүсэлтийг Дэлхийн банкинд тавьж, үүнд шаардагдах хөрөнгийн талаар та бүхний саналыг сонсох гэж өнөөдөр цуглуулсан юм. Янз бүрийн бичиг цаас, журам дүрмийн дагуу энэ асуудлыг тавьдаг тул хоног хугацаа алдалгүйгээр хөрөнгө мөнгөө шийдүүлэх шаардлага байна. Хуралдаанаар дараахь асуудлыг хэлэлцэнэ.

Хэлэлцсэн асуудлууд:

1. ОУИТБС-ын 2007-2008 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан

/Ажлын албаны зохицуулагч Ш. Цолмон/

2. ОУИТБС-ын хүрээнд Дэлхийн банкнаас 2009-2010 онд санхүүжилт хүсэх хөрөнгийн тооцоо

/Ажлын албаны зохицуулагч Ш. Цолмон/

Д.Батбаяр-Эхний хэлэлцэх асуудлаар Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон мэдээлэл хийнэ.

Ажлын албаны зохицуулагч Ш. Цолмон 2007-2008 онд хийсэн ажлын талаар болон 2009-2010 онд санхүүжилт хүсэх төсвийн талаар нэгтгэн танилцуулав. (Мэдээллүүдийг хавсаргав)

Д.Батбаяр: Асууж тодруулах зүйл байна уу?

Н.Дорждарь: За мэдээж нэмж санхүүжилт олдвол авч байх хэрэгтэй гэж бодож байна. Би Батбаяр зөвлөхөөс нэг юм асууя. Катарын Доха-д болох ОУИТБС-ын дээд хэмжээний уулзалтанд Ерөнхий сайд оролцох болов уу? Тэр талаар мэдээлэл байгаа юу?

Д.Батбаяр: Энэ арга хэмжээний талаар Ерөнхий сайдад танилцуулсан байгаа. Яг одоогоор оролцоно, оролцохгүй гэсэн хариу надад өгөөгүй байна. Ер нь бол чухал арга хэмжээ, оролцох нь ач холбогдолтой гэдгийг бид мэдэж байгаа.

Р.Батпүрэв: Дэлхийн банкнаас санхүүжилт өгөх юм бол авах нь зөв өө. Би дэмжиж байна. Харин төсөв хөрөнгөндөө төрийн бус байгууллагуудыг дэмжсэн, санхүүгийн тодорхой дэмжлэг үзүүлэхээр хөрөнгийг тусгах боломж байна уу?

Ц.Мөнхбаяр: Гадны байгууллагаар аудит хийлгэхээр мөнгө дахиад тавьсан байна. Ажлын арга барилын хувьд урьд хийснээсээ өөрчлөгдөх үү? Татварын дүн зөрсөн гэж яриад байдаг, үүнийг ойлгохгүй юм, хэрэв татварынхаа дүнг зөрүүлээд байгаа бол дэмжлэг, хураамж эд нар дээр бүүр ч аюул болно биз дээ. Цаашдаа арга барилаа өөрчлөх хэрэгтэй гэж бодож байна.

Д.Батбаяр: Төрийн бус байгууллагуудын хүчин зүтгэл, та бүхний үйл ажиллагааны үр дүнд ОУИТБС Монгол Улсад өнөөдрийн байдалтай хэрэгжиж байгаа юм шүү. Гэхдээ тайланг буруу зөв гаргах асуудал байгаа. Сургалтын чанарыг сайжруулах хэрэгтэй, сургалтанд хамрагдсан ажилтнуудын тогтвор суурьшилгүй байдал ч бас сөргөөр нөлөөлсөн биз ээ.

Н.Дорждарь: Дэлхийн банк дээр энэ төслийн төсөв нь очихоор дараагийн төслийн юуг нь сайжруулсан бэ, ямар зүйлд анхаарлаа хандуулсан бэ гэх мэт асуултууд тавигдах байх. Өөрөөр хэлбэл ажлын хүрээгээ өргөжүүлэх, лицензийн асуудал, гэрээ, хэлэлцээрийн талаар өргөн хүрээнд ажиллах гэх мэт. Тэгэхээр наад захын шаардлагаас нь хальсан байдлаар асуудалд хандаасай. Энэ нь Монгол Улсын нэр хүндээс гадна өөрөө зөв механизмыг гаргаж ирэх болно шүү.

Д.Батбаяр: Компаниуд ч өөрсдөө ил тод байхыг хүсдэг зөв гольдрилд нь оруулах шаардлага бидэнд байгаа.

Н.Алгаа: Нэгэнт ил тод байлгая гэж байгаа учир АМГТХЭГ ч гэсэн өөрөөсөө эхлэх ёстой байх. АМГТХЭГ-аас 1997 онд кадастрын ил тод байдалтай холбоотой мэдээллийг гаргадаг байсан. Сүүлдээ ч алга болсон. Одоо бол бүүр нээлттэй байтугай бүүр хаалттай маягийн болчихсон байна шүү дээ.

Р.Батпүрэв: 2009-2010 онд ОУИТБС-ыг хэрэгжүүлэх төсөв дээр татвар, АМГТХЭГ дээр тусдаа хариуцсан ажилтан байлгана, цалинжуулна гэдгийг дэмжиж байна. Үндэсний зөвлөлийн хурал хэзээ болох вэ? Энэ асуудлыг Үндэсний зөвлөлөөр дэмжүүлэх хэрэгтэй гэж бодож байна. Өөр нэг асуудал бол аймгийн зөвлөл гэж ажил хийдэг эсэх нь тодорхойгүй байна. Аймгийн зөвлөлийн ажлыг эрчимжүүлэх шаардлага байна.

Д.Батбаяр: Одоогийн байдлаар бүх л яам, тамгын газрын бүтэц өөрчлөгдөөд, зарим гишүүд маань томилогдоогүй байна. Үндэсний зөвлөлд албан тушаалын дагуу ордог болохоор нөхцөл байдал цэгцрэхээр хуралдуулна гэсэн төлөвлөгөөтэй байна.

Асуулт дуусаж санал хэлэв.

Ц.Ганболд: Ажлын алба 2 хүний бүрэлдэхүүнтэй ажилладаг. Ямар ч байсан урьд бидний ажлын албагүй ажиллаж байснаас хамаагүй илүү ажил хийгдсэн. Ажлын албаны 2 хүнийг муугүй ажиллаж байна гэж би дүгнэж байгаа. Надад хэдэн санал байна. Нэгдүгээрт 2007 оны компаниудаас ирүүлсэн ОУИТБС-ын тайланг хэвлэлд нийтэлмээр байна. Хоёрт гэвэл олборлох үйлдвэрлэлтэй холбоотойгоор гаалийн үйл ажиллагааг ч бас ил тод болгомоор байна. Урагшаа, хойшоо гарч байгаа юмаа сайн тооцох хэрэгтэй. Жишээ болгоод хэлэхэд Тамсагийн нефть олборлох үйл ажиллагааг АМГТХЭГ-ын ажилтнууд 45 хоногоор ээлжилж хянадаг гэж байгаа юм. Тэнд үнэхээр 2000 баррель олборлов уу, эсхүл 4000-г олборлочихоод хэсгийг нь тэр хүнд өгчихсөн байна уу гэдгийг мэдэх боломж байхгүй байна. Иймээс хил, гаалийн үйл ажиллагааг сайжруулж, ил тод болгох хэрэгтэй. Орон нутгийн түвшинд 3 талын ажиллагааг сайжруулах талаар бид өөрсдөө ч бас чадлаараа дэмжих хэрэгтэй. Хугацаандаа тайлагнах талаар компаниудыг Сангийн яам, Татварынханаар шахуулвал дээр байх. Бас тэр АМГТХЭГ лиценз өгч байгаа, буцаан авч байгаагаа ил тод байлгах хэрэгтэй юм. ОУИТБС үүнээс л эхэлнэ. Энэ салбарт тэргүүлэх орон байхын тулд зөвхөн тайлан гаргах дээрээ эргэлдээд байлгүй арай өөр хүрээнд цогцоор нь бүх мэдээллийг ил тод, хүртээмжтэй, нээлттэй болгомоор байна. Энэ төслийн хувьд бол санхүүжилт авахыг дэмжиж байна.

Н.Алгаа: Дэлхийн банкнаас санхүүжилт авахыг дэмжилгүй яах вэ. Харин Монголд үлдэх байдлаар зарцуулах тал дээр анхаараарай. Жишээ нь сурталчилгаагаа идэвхжүүлэх.

Ц.Ганболд: Яах вэ 2010 он хүртэл Дэлхийн банкнаас санхүүжилт олчихлоо гэхэд цаашдаа энэ бүтцийг хадгалж, үйл ажиллагаагаа үргэлжлүүлж явахыг л зорих хэрэгтэй байна. Товхимолыг зөвхөн англи дээр хэвлэнэ гэж төсөвт орсон байна. Монгол дээр хэвлэж болдоггүй юм уу. *(хэл)*

Цэгц: Энэ төсөв дээр сургалтын тоог арай ихэсгэх боломж байгаа юу. Бага юм шиг санагдаж байна. Бас тэр тайлан бөглөх талаар үлгэрчилсэн загвар хийвэл ойлгомжтой байх болов уу гэж бодогдож байна.

Ц.Мөнхбаяр: Аймаг орон нутагт ОУИТБС-ын хэрэгжилт хангалтгүй байна гэх юм. Ерөнхий сайдаас аймгийн Засаг дарга нарт үүрэг болгож болдоггүй юм уу. Цаашлаад аймаг гэлтгүй суманд ч хэрэгжүүлэх шаардлага байна гэж үзэж байна. Бид нарыг ч дайчилж болно шүү дээ.

Ш.Цолмон: За та бүхний санал, зөвлөгөөнүүдийг сонслоо. Чухал хэрэгтэй санаа оноонууд байна. Төсвийн төсөлдөө тусгая. Ажлын хажуугаар, цаг заваа зориулан ирцгээсэнд тань баярлалаа.

Ажлын хэсгийн хурал 17 цаг 00 минутад дуусав.

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:



Ерөнхий сайдын ахлах зөвлөх,
Ажлын хэсгийн ахлагч
Д.Батбаяр

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:



ОУИТБС-ын Ажлын албаны
ажилтан Т.Хүрэлчимэг